

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 30 дугаар цэцэрлэг 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/89/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Гантулга Утас: 99372297 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 30 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Х.ОТГОНТУЯА ТАНАА

2025.02.25 № 128

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 30 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 30 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд Дархан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 6,684.0 мянган төгрөгийн хүүхдийн сэтгэхүй хөгжүүлэх тоглоом, 3,033.9 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж болон 4 ш компьютерийг тус тус хүлээн авч, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны А/36 тоот тушаалын дагуу бүртгэж, санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 129,872.5 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 20 хувиар өссөн байна.

4526050082

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 30 дугаар цэцэрлэгийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 54 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 98 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр аймгийн Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	257,471,090.11	120,534,582.04
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	208,400,455.11	50,392,033.38
312	Банкинд байгаа	208,400,455.11	50,392,033.38
3121	Төгрөг	208,400,455.11	50,392,033.38
31211	Төрийн сангийн харилцах	208,400,455.11	50,392,033.38
35	БАРАА МАТЕРИАЛ	49,070,635.00	70,142,548.66
35130	Эм боох материал	1,192,400.00	305,000.00
354	Хангамжийн материал	47,878,235.00	69,837,548.66
35410	Бичиг хэргийн материал	3,221,500.00	4,486,000.00
35420	Аж ахуйн материал	2,101,500.00	450,000.00
35450	Барилгын засварын материал	4,376,710.00	4,203,300.00
35460	Хүнсний материал	7,847,166.00	8,263,482.00
35470	Бусад хангамжийн материал	30,331,359.00	52,434,766.66
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	110,698,204.49	95,749,655.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	110,698,204.49	95,749,655.03
392	Биет хөрөнгийн дүн	109,648,204.49	94,830,905.03
39201	Барилга байгууламж	3,465,300.00	3,465,300.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,443,875.00)	(1,790,405.00)
39205	Машин тоног төхөөрөмж	77,148,450.00	83,648,060.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,842,553.17)	(29,911,139.98)
39207	Тавилга, эд хогшил	54,092,995.60	39,104,515.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,380,612.82)	(18,966,675.43)
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,700,000.00	23,700,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,187,500.12)	(4,418,750.16)
39217	Ном	96,000.00	-
393	Биет бус хөрөнгийн дүн	1,050,000.00	918,750.00
39301	Программ хангамж	1,050,000.00	1,050,000.00
39302	Хасагдуулга	-	(131,250.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	368,169,294.60	216,284,237.07
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	368,169,294.60	216,284,237.07
51	Засгийн газрын хувь оролцоо	368,169,294.60	216,284,237.07
512	Хуримтлагдсан үр дүн	368,169,294.60	216,284,237.07
51210	Өмнөх үеийн үр дүн	368,169,294.60	368,169,294.60
51220	Тайлант үеийн үр дүн	-	(151,885,057.53)
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	368,169,294.60	216,284,237.07

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,123,349,601.00	962,397,520.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,901,801.00	31,300,720.00
120	Нийтлэг татварын бус орлого	100,901,801.00	31,300,720.00
12004	Төсөв байгууллагын өөрийн орлого	69,763,402.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,285,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	69,763,402.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	29,969,400.00	13,468,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,168,999.00	13,547,020.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,022,447,800.00	931,096,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	960,447,800.00	866,270,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	960,447,800.00	866,270,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,000,000.00	64,826,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,000,000.00	64,826,200.00
2	Үйл ажиллагааны зардал	1,012,804,262.18	1,114,282,577.53
21	Урсгал зардал	1,012,804,262.18	1,114,282,577.53
210	Бараа, үйлчилгээний зардал	1,008,200,828.87	1,104,726,973.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	650,001,645.29	779,874,117.23
210101	Үндсэн цалин	456,295,854.29	528,413,205.18
210102	Нэмэгдэл цалин	172,346,194.00	202,540,527.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	26,783,000.00
210104	Урамшуулал	21,359,597.00	22,137,385.00
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	83,882,743.51	96,465,173.50
210201	Тэтгэврийн даатгалын	57,797,575.29	66,324,183.89
210202	тэтгэмжийн даатгалын	6,714,055.01	7,159,229.12
210203	ҮОМШӨ-ий даатгалын	3,221,168.12	3,805,989.38
210204	Ажилгүйдлийн даатгалын	3,177,994.00	3,798,183.08
210205	ЭМ-ийн даатгалын	12,971,951.09	15,377,588.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,896,566.69	52,701,195.68
210301	Гэрэл цахилгааны зардал	12,038,969.57	18,129,423.40
210302	Түлш, халаалтын зардал	10,796,474.16	8,541,310.80
210303	Цэвэр бохир усны зардал	6,061,122.96	7,780,948.20
210304	Байрны түрээс	16,000,000.00	18,249,513.28
2104	Хангамж, бараа материалын зардал	8,244,400.00	31,602,893.18
210401	Бичиг хэргийн зардал	8,244,400.00	8,191,200.00
210406	Бараа материал акталсны зардал	-	23,411,693.18
2105	Нормативт зардал	102,313,392.00	103,595,725.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	192,600.00	551,000.00
210502	Хоол, хүнс	102,120,792.00	103,044,725.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,443,452.00	2,355,900.00
210604	Урсгал засварын зардал	68,443,452.00	2,355,900.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	3,147,447.58	1,684,090.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	3,147,447.58	1,684,090.00
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	47,271,181.80	36,447,878.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,426,227.58	18,731,210.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,844,954.22	17,716,668.62
213	Урсгал шилжүүлэг	4,603,433.31	9,555,604.32
	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	5,430,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,603,433.31	4,125,004.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,603,433.31	4,125,004.32
3	Үйл ажиллагааны үр дүн	110,545,338.82	(151,885,057.53)
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	110,545,338.82	(151,885,057.53)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,022,447,800.00	935,382,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,285,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	4,285,700.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	4,285,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,285,700.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,022,447,800.00	931,096,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	960,447,800.00	866,270,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	960,447,800.00	866,270,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,000,000.00	64,826,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,000,000.00	64,826,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	933,204,558.96	1,091,966,021.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	933,204,558.96	1,091,966,021.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	928,601,125.65	1,082,410,417.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	650,001,645.29	779,345,719.18
210101	Үндсэн цалин	456,295,854.29	528,413,205.18
210102	Нэмэгдэл	172,346,194.00	202,012,129.00
210103	Хоол унаа хөнгөлөлт	-	26,783,000.00
210104	Урамшуулал	21,359,597.00	22,137,385.00
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,882,743.51	96,993,571.55
210201	Тэтгэврийн даатгалын	57,797,575.29	66,324,183.89
210202	Тэтгэмжийн даатгалын	6,714,055.01	7,687,627.17
210203	ҮОМШӨ-ий даатгалын	3,221,168.12	3,805,989.38
210204	Ажилгүйдлийн даатгалын	3,177,994.00	3,798,183.08
210205	Эрүүл мэндийн даатгалын	12,971,951.09	15,377,588.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,896,566.69	52,701,195.68
210301	Гэрэл цахилгааны зардал	12,038,969.57	18,129,423.40
210302	Түлш, халаалтын зардал	10,796,474.16	8,541,310.80
210303	Цэвэр бохир усны зардал	6,061,122.96	7,780,948.20
210304	Байрны түрээс	16,000,000.00	18,249,513.28
2105	Нормативт зардал	103,873,045.00	103,461,041.00
210502	Хоол, хүнс	103,873,045.00	103,461,041.00
2106	Эд хогшил урсгал засвар	12,500,000.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	12,500,000.00	8,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	3,311,847.58	5,010,090.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	3,311,847.58	5,010,090.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,135,277.58	36,898,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,147,677.58	27,432,600.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	9,987,600.00	9,466,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,603,433.31	9,555,604.32
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	5,430,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,603,433.31	4,125,004.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,603,433.31	4,125,004.32
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	89,243,241.04	(156,583,521.73)
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	550,000.00	1,424,900.00

22	Хөрөнгийн зардал	550,000.00	1,424,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	550,000.00	1,424,900.00
223001	Бусад хөрөнгө	550,000.00	1,424,900.00
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(550,000.00)	(1,424,900.00)
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	88,693,241.04	(158,008,421.73)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		208,400,455.11
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		50,392,033.38

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	368,169,294.60	368,169,294.60
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
ҮХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	151,885,057.53	151,885,057.53
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	368,169,294.60	368,169,294.60
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
ҮХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(151,885,057.53)	(151,885,057.53)
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	216,284,237.07	216,284,237.07

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	935,382,500.00	926,971,795.68	(8,410,704.32)	99
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	870,556,300.00	866,270,600.00	(4,285,700.00)	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	870,556,300.00	866,270,600.00	(4,285,700.00)	100
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	64,826,200.00	60,701,195.68	(4,125,004.32)	94
132001	Орон нутгийн төсвөөс	64,826,200.00	60,701,195.68	(4,125,004.32)	94
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	208,400,455.11	4,285,700.00	(204,114,755.11)	2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,285,700.00	4,285,700.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	208,400,455.11	-	(208,400,455.11)	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,143,782,955.11	931,257,495.68	(212,525,459.43)	81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,142,609,900.00	1,089,265,917.41	(53,343,982.59)	95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,137,179,300.00	1,083,835,317.41	(53,343,982.59)	95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	805,209,500.00	779,345,719.18	(25,863,780.82)	97
210101	Үндсэн цалин	556,517,800.00	528,413,205.18	(28,104,594.82)	95
210102	Нэмэгдэл	231,948,800.00	202,012,129.00	(29,936,671.00)	87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	26,783,000.00	26,783,000.00	-
210104	Урамшуулал	16,742,900.00	22,137,385.00	5,394,485.00	132
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,021,300.00	96,993,571.55	(3,027,728.45)	97
210201	Тэтгэврийн даатгал	67,813,000.00	66,324,183.89	(1,488,816.11)	98
210202	Тэтгэмжийн даатгал	8,052,100.00	7,687,627.17	(364,472.83)	95
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,026,000.00	3,805,989.38	(220,010.62)	95
210204	Ажилгүйдлийн даатгал	4,026,000.00	3,798,183.08	(227,816.92)	94
210205	Эрүүл мэндийн даатгал	16,104,200.00	15,377,588.03	(726,611.97)	95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,035,700.00	52,701,195.68	(12,334,504.32)	81
210301	Гэрэл, цахилгаан	20,075,000.00	18,129,423.40	(1,945,576.60)	90
210302	Түлш, халаалт	16,532,700.00	8,541,310.80	(7,991,389.20)	52
210303	Цэвэр, бохир ус	9,229,600.00	7,780,948.20	(1,448,651.80)	84
210304	Байрны түрээс	19,198,400.00	18,249,513.28	(948,886.72)	95
2105	Нормативт зардал	115,157,700.00	103,461,041.00	(11,696,659.00)	90
210502	Хоол, хүнс	115,157,700.00	103,461,041.00	(11,696,659.00)	90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	8,000,000.00	-	100
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,123,800.00	5,010,090.00	(113,710.00)	98
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,123,800.00	5,010,090.00	(113,710.00)	98
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,631,300.00	38,323,700.00	(307,600.00)	99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,165,100.00	28,857,500.00	(307,600.00)	99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,466,200.00	9,466,200.00	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,430,600.00	5,430,600.00	-	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,430,600.00	5,430,600.00	-	100

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,430,600.00	5,430,600.00	-	100
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,142,609,900.00	1,089,265,917.41	(53,343,982.59)	95
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	208,400,455.11	208,400,455.11	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	50,392,033.38	50,392,033.38	-
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100
3	Төсвийн байгууллага	1	1	0.00	100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35	33	(2.00)	94
6	Удирдах ажилтан	1	1	0.00	100
7	Гүйцэтгэх ажилтан	25	23	(2.00)	92
8	Үйлчлэх ажилтан	8	8	0.00	100
9	Гэрээт ажилтан	1	1	0.00	100

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,337.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд төсвийг хохиролгүй болгох 600.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг таслан зогсоох 5,737.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Илрүүлэлт: Тус цэцэрлэгийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч Х.Отгонтуяагийн сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”-ын хавсралт “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар”-ын 3-д “Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

5.2.1.Илрүүлэлт: Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч Х.Отгонтуяа нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,619.2 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна”, 27.6-д “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална”, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт “Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

5.2.2.Илрүүлэлт: Тус цэцэрлэгийн нягтлан бодогч С.Дарьчимэгд Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн А/13 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар “өөрчлөлтгүй” дүгнэлт авсан тул нэг сарын

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүлж, 3,118.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-д *“Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай”*, “Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.8-д *“Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно”* гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус цэцэрлэгийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч Х.Отгонтуяаийн сургалтын төлбөрт 600,000.00 төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	600.0	1	600.0	-	-	-	-	-	-	-	-
Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч Х.Отгонтуяа нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,619,200.00 төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.	1	2,619.2	-	-	1	2,619.2	-	-	-	-	-	-
Тус цэцэрлэгийн нягтлан бодогч С.Дарьчимэгд Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн А/13 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүлж, 3,118,000.00 төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.	1	3,118.0	-	-	1	3,118.0	-	-	-	-	-	-
Дүн	3	6,337.2	1	600.0	2	5,737.2	-	-	-	-	-	-